

ИНВЕСКОР ББСБ ХК-ИЙН 2023 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо:	2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 14 цаг
Хуралдсан хэлбэр:	Компанийн вэб хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр
Хурлын ирц:	94,55 хувь
Саналын эрхийн тоо:	75,744,280 ширхэг энгийн хувьцаа
Хурлын дарга:	Гүйцэтгэх захирал Д.Баясгалан
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:	Б.Гандарь
Тооллогын комиссын гишүүд:	Ж.Азбаяр Б.Чулуунчимэг Ж.Солонго Л.Оюундарь

Хэлэлцсэн асуудал:

1. Инвескор ББСБ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулж, уг тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлах
3. Инвескор ББСБ ХК-ийн хувьцааг хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах
4. Давуу эрхийн хувьцаа гаргах
5. Инвескор ББСБ ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлах

Тооллогын комиссын дарга Э.Азбаяр: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 71,617,892 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байна. нийт компанийн саналын эрх бүхий 75,744,280 ширхэг энгийн хувьцааны 94,55 хувьтай тэнцэж байгаа тул өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хүчин төгөлдөр бүрдсэн болохыг мэдэгдэж байна.

Инвескор ББСБ ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Гүйцэтгэх захирал Д.Баясгалан нээж, хурлын дэгийг танилцуулав.

Модератор: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан, Тэргүүн дэд захирал Н.Арсланбаатар, Санхүү хариуцсан захирал С.Тулга болон Инвескор хэтэвч ББСБ ХК-ийн Санхүү төлөвлөлт, стратеги хариуцсан захирал Г.Ган-Эрдэнэ, хурлын тооллогын комиссын гишүүд болон хөндлөнгийн аудитаар Лидер Экаунт Аудит ХХК-ийг төлөөлж захирал Ш.Уянга нар оролцож байна.

Хэлэлцсэн асуудал 1: Инвескор ББСБ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулж, уг тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах

Гүйцэтгэх захирал Д.Баясгалан: Компанийн 2022 оны үйл ажиллагааны талаар танилцуулав. Бид өнгөрсөн жил Европын сэргээн босголт хөгжлийн банкттай 5 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн зээлийн санхүүжилт авах гэрээг байгуулав. Мөн өнгөрсөн жилд бидний хийсэн томоохон ажлуудын нэг бол Олон улсын MicroFinanza Rating байгууллагаас авсан үнэлгээгээ “А” болгож ахиуллаа. Ингэснээрээ бид санхүүгийн салбарт “А” үнэлгээ авч чадсан 5 компанийн нэг болж чадсан юм. Түүнчлэн Pocket LG компанийг Киргиз улсад үйл ажиллагаа явуулж, зах зээлд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна. Мөн бид ISO/IEC 27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын стандарт болон ISO/IEC 9001:2015 Чанарын удирдлагын стандартыг компанийнхаа дотоод үйл ажиллагаа болон ажилчдынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн бид энэ жил хувьцаа эзэмшигчдэдээ 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 38 төгрөг буюу нийт 2.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна. 2023 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар компанийн хувьцааны хаалтын ханш нэгж хувьцаанд 5595 төгрөг буюу IPO-с хойш 239 хувийн өсөлттэй байна. Мөн бид үйл ажиллагаандаа БОНЗ-ыг нэвтрүүлж, БОНЗ-ын зарчмуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тэргүүн дэд захирал Н.Арсланбаатар: Компанийн 2022 оны зээлийн багц, зээлийн багцын чанар, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн талаар танилцуулав. Нийт зээлийн багц 63 хувиар өсч 282.6 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт зээлдэгчдийн тоо 182,000-д 128,000 хувиар өслөө. Мөн бид Монгол Улсад нийт 17 салбартай, Киргиз улсад 4 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Киргиз улс дахь охин компанийн зээлийн багц 17 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 150 хувиар зээлийн багц өслөө. Зээлийн багцын чанарын хувьд банк болон ББСБ-ын салбартай харьцуулахад 1.5-2 дахин сайн байна. Бид үйл ажиллагаандаа технологийн шийдлийг нилээд ашиглаж, зээл олголтын шийдвэр гаргалтын цагийг багасгаж, харилцагчид хүндрэл учруулахгүй зайнаас үйлчилгээ авах боломжийг олгох тал дээр анхаарч ажиллаж байна.

Санхүү хариуцсан захирал С.Тулга: Компанийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар танилцуулав. Компанийн хувьд үйл ажиллагаандаа хэрэглэж буй автоматжуулалтын хувьд үйл ажиллагааны зардал тогтмол буурч байна. Үүний үр дүнд компанийн нийт цэвэр ашиг 33.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 75 хувиар нэмэгдсэн. Жилийн цэвэр өсөлт 16.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны үеэс 2 дахин нэмэгдсэн амжилттай байна. Цэвэр ашгийн төлөвлөгөөгөө бид 9.3 тэрбум төгрөгөөр буюу 38 хувиар давуулан биелүүллээ. Бид СЗХ болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас тавьж байгаа зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилладаг. Өрийн харьцаа 68 хувьтай, өөрийн хөрөнгийн хүрэлцээ 32 хувьтай байгаа нь СЗХ-ны шаардлагаас 3 дахин өндөр байгааг харуулж байна. Хөрвөх чадварын харьцааны хувьд 25.3 хувьтай, гадаад валютын нээлттэй позицын хувьд 2022 оны төгсгөлд 3 хувьтай барьж ажилласан.

Модератор: Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Хэлэлцсэн асуудал 2: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Б.Гандарь: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийн саналын талаар танилцуулав. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв нь ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин урамшуулал, томилолтын зардал, хурлын зардал болон бусад зардал буюу нийт 159,200,000 төгрөгөөс бүрдэж байгаа бөгөөд уг саналыг батлуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж байна.

Хэлэлцсэн асуудал 3: Компанийн хувьцаа хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах

Санхүү хариуцсан захирал С.Тулга: Компанийн хувьцаа хуваах Компанийн тухай хуульд заасан үндэслэл, хувьцаа хуваах үйл ажиллагааны дараалал, хувьцаа хуваахын давуу тал, хувьцаа хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах саналын талаар танилцуулав.

Хэлэлцсэн асуудал 4: Давуу эрхийн хувьцаа гаргах

Санхүү хариуцсан захирал С.Тулга: Давуу эрхийн хувьцаа гаргахтай холбоотой хууль, эрх зүйн орчин, давуу эрхийн хувьцаа гаргаснаар Компани болон хөрөнгө оруулагчдад үүсэх давуу тал, давуу эрхийн хувьцааны нөхцөлийн талаар тус тус танилцуулав.

Хэлэлцсэн асуудал 5: Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлт

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Б.Гандарь: Компанийн хувьцаа хуваах, давуу эрхийн хувьцаа гаргах, Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл хасагдах болон эрх бүхий албан тушаалтан нэмэгдсэнтэй холбоотойгоор Компанийн дүрэмд орж байгаа нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар танилцуулав.

Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариулт

Асуулт 1: Нэгж хувьцаанд ногдох ашиг өмнөх жилүүдийнхээс өсч чадсан уу? Ямар ногдол ашгийн бодлого баримталж байна вэ?

Гүйцэтгэх захирал Д.Баясгалан: Бид энэ жил хувьцаа эзэмшигчдэдээ нийт 2,9 тэрбум ногдол ашгийг хуваарилах шийдвэр гарсан. Ногдол ашиг цэвэр ашиг өсч байгаатай холбоотойгоор жил бүр өсөж байгаа. Цаашид бид бүхэн тухайн жилийн цэвэр ашгийн 5-10 хувийг ногдол ашиг болгон хуваарилах бодлого баримтлан ажиллах болно.

Асуулт 2: Энэ оны байдлаар хэдэн хувьцаа эзэмшигчтэй байна вэ?

Модератор: Ойролцоогоор 1600 орчим хувьцаа эзэмшигчтэй байна.

Асуулт 3: Давуу эрхийн хувьцаа гаргаснаар энгийн хувьцаанд хэрхэн нөлөөлнө гэж үзэж байна вэ? Цаашид санхүүгийн тогтвортой өсөлтийг хэрхэн хангаж ажиллах вэ?

Санхүү хариуцсан захирал С.Тулга: Давуу эрхийн хувьцаа гаргаснаар компанийн өөрийн хөрөнгө болон харилцагчдад олгож байгаа зээлийн хөрөнгө нэмэгдэнэ. Ингэснээр компанийн зээлийн хүүгийн орлого болон цэвэр ашиг мөн нэмэгдэнэ. Энэ нь компанийн энгийн хувьцаанд эсрэг нөлөөтэй байна.

Гүйцэтгэх захирал Д.Баясгалан: Компани маань өөрийн үйл ажиллагаандаа тавигддаг олон улсын стандарт, шаардлагуудыг ханган ажиллаж байна. Түүнчлэн бид ирэх 5 жилийн стратеги төлөвлөгөөгөө баталсан бөгөөд үүнд нийцүүлэн жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлдэг.

Асуулт 3: 5 жилийн дараах Компанийг хэрхэн харж байна вэ?

Гүйцэтгэх захирал Д.Баясгалан: Бид компаниа 5 жилийн дараа Төв Азийн зах зээлд тэргүүлэгч санхүүгийн байгууллага болно гэж харж байна. Түүнчлэн 2027 оны эцэс гэхэд компанийн нийт активыг 1,5 их наяд болгоно гэсэн дүр зураг харагдаж байна. Мөн технологийн шийдүүдийг ашигласан, илүү технологижсон компани болох зорилготой.

Асуулт 4: Танай зээлийн хүү дунджаар хэд байгаа вэ? Төв Азид явуулж байгаа үйл ажиллагаа хэр түвшинд явж байна вэ?

Тэргүүн дэд захирал Н.Арсланбаатар: Зээлийн хүүний хувьд бүтээгдэхүүний онцлог, эрсдэлийн түвшингээс хамаараад ялгаатай байдаг бөгөөд сарын 2,5-3,2 хувийн хүүтэй байна. Мөн Рио Тинтотой хамтарсан хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээлийн хувьд сарын 0,4 хувийн хүүтэй зээлийг олгож байна. Өнөөдрийн байдлаар бид Төв Азийн 4 улсад үйл ажиллагаа явуулж байна. Киргиз улсад 2 компани байгуулсан бөгөөд нэг нь уламжлалт чиглэлээр, нөгөөх нь финтек чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Бид Төв Азид үйл ажиллагаа явуулахдаа анхнаасаа зах зээлийн судалгааг маш сайн хийсэн.

Асуулт 5: Автомашины зээл авбал хувьцаа эзэмшигчдэд хөнгөлөлт олгохуу ?

Тэргүүн дэд захирал Н.Арсланбаатар: Компанийн 5 хувиас дээш хувьцааг эзэмшиж байгаа этгээд нь Компанийн холбоо хамааралтай этгээд болох учраас тэдгээрт аливаа байдлаар давуу тал бий болгохыг хориглодог бөгөөд нөгөө талаас бид харилцагчаа хамгаалах зарчим баримталдаг бөгөөд харилцагчдадаа үйлчилгээгээ тэгш, хүртээмжтэй хүргэх, нөгөө талаас хувьцаа эзэмшигчдэд хөнгөлөлттэй зээл олгохыг хориглодог.

Асуулт 6: 2023 онд хийхээр төлөвлөж байгаа ажлууд юу вэ?

Тэргүүн дэд захирал Н.Арсланбаатар: Бид 2023 онд автомашин худалдах авах болон бизнесийн зээлийг харилцагчдад чирэгдэлгүй, зайнаас олгох, хялбарчлах зорилгоор автоматжуулалтын ажлыг эрчимжүүлэх, түүнчлэн олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөтгөхөөр зорин ажиллаж байна.

Асуулт 7: Хувьцаа хуваах шийдвэрт яагаад өөрчлөлт оруулж байгаа вэ?

Санхүү харнуцсан захирал С.Тулга: 2022 онд төгрөгийн ханш ам долларын эсрэг 6 хувиар суларсан. Хувьцааг 100 хувааснаар нэгж энгийн хувьцааны үнэ 50-60 төгрөг болно. Үүнийг ам.доллараар илэрхийлбэл гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Компанийн имиджид сөргөөр нөлөөлөхөөр байсан. Иймд хувьцааг нэг дор 100 хуваах биш эхний ээлжинд 10 хуваагаад цаашид үе шаттайгаар хуваагаад явах санал гаргаж байна.

Асуулт 8: Покетын шинээр хийгдэж байгаа шинэчлэлтүүд юу байгаа вэ?

Инвескор Хэтгэвч ББСБ ХХК-ийн Санхүү төлөвлөлт, стратеги хариуцсан захирал Г.Ган-Эрдэнэ: Монголд анхдагчид тооцогдох metaverse дах Покет дэлгүүрийг нээсэн. Түүнчлэн саяхан урт хугацаат зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн бөгөөд амжилттай явж байна. Мөн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсантай холбогдуулан цаашид өөрийн аппликэйшнаараа дамжуулан итгэлцлийн үйлчилгээ явуулахаар төлөвлөж байна.

Санал хураалтын цаг эхэлж, хувьцаа эзэмшигчид саналаа өгөв. Үүний дараа Тооллогын комиссын дарга Ж.Азбаяр хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчид хэлэлцсэн асуудал дор дурдсан байдлаар саналаа өгөв. Үүнд:

1. Компанийн Инвескор ББСБ ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулж, уг тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99,34 хувь нь зөвшөөрсөн, 0,27 хувь нь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99,34 хувь нь зөвшөөрсөн, 0,27 хувь нь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн;
3. Инвескор ББСБ ХК-ийн хувьцааг хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99,61 хувь нь зөвшөөрсөн, 60 ширхэг буюу 0 хувь нь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн
4. Давуу эрхийн хувьцаа гаргах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99,29 хувь нь зөвшөөрсөн, 0, 32 хувь нь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн;
5. Инвескор ББСБ ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99,61 хувь нь зөвшөөрсөн, 40 ширхэг буюу 0 хувь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

Нэгдүгээрт. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.10 дах заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын _____ дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаарт. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.14 дэх заалт болон хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ____ дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.

Гуравдугаарт. Компанийн хувьцаа хуваах шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.6 дах заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.6 дах заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ____ дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн №А/05 тоот “Компанийн хувьцаа хуваах төслийг батлах тухай” тогтоолыг дараах байдлаар өөрчилсүгэй. Үүнд:
 - 1.1.Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 82,000,000 ширхэг зарласан энгийн хувьцааны нэг хувьцаа бүрийг 10 хувааж, нэг бүр нь 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 820,000,000 ширхэг зарласан энгийн хувьцаа болгон хуваасугай.
 - 1.2.Компанийн нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 75,744,281 ширхэг гаргасан энгийн хувьцааны нэг хувьцаа бүрийг 10 хувааж, нэг бүр нь 22.7 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 757,442,810 ширхэг гаргасан энгийн хувьцаа болгон хуваасугай.
 - 1.3.Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
 - 1.4.Энэхүү тогтоолоор батлагдсан “Хувьцаа хуваах төсөл”-ийг хэрэгжүүлэх, Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хувьцаа хуваах хүсэлт гаргах, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, зөвшөөрөл авах болон бусад эрх бүхий байгууллагад мэдээлэл хүргүүлэх, бүртгүүлэх, зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д даалгасугай.
 - 1.5.Хувьцаа хуваах шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсны дараа “Хувьцаа хуваах төсөл”-ийн хамтаар баталсан Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д. Баясгалан)-д даалгасугай.
2. Энэхүү тогтоолоор баталсан “Хувьцаа хуваах төсөл”-ийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

Дөрөвдүгээрт. Хаалттай хүрээнд давуу эрхийн хувьцаа гаргах,
компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дах заалт, 35 дугаар зүйлийн 35.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.5, 6 дугаар зүйлийн 6.13, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ____ дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор нэг бүр нь 5,000 (таван мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,000,000 (зургаан сая) ширхэг, нийт 30,000,000,000 (гучин тэрбум) төгрөгийн үнэтэй давуу эрхийн хувьцааг зарласугай.
2. Компанийн зарласан давуу эрхийн хувьцааг дараах нөхцөлөөр гаргасугай. Үүнд:

Гаргах хэлбэр	Хаалттай хүрээнд
Зорилго	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх
Нийт гаргах давуу эрхийн хувьцааны тоо ширхэг	6,000,000 (зургаан сая)
Давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ	5,000 (таван мянган) төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	30,000,000,000 (гучин тэрбум) төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх
Давуу эрхийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнэ	Нэрлэсэн үнээр буюу нэг бүр нь 5,000 (таван мянган) төгрөг
Давуу эрхийн хувьцааны саналын эрх	Давуу эрхийн нэг хувьцаа нэг саналын эрхтэй
Давуу эрхийн хувьцааны нөхцөл	Компани эргүүлэн худалдан авах нөхцөлтэй
Хувьцаа эзэмшигч давуу эрхийн хувьцааг компанид эргүүлэн худалдах эрхээ хэрэгжүүлэх хугацаа	Давуу эрхийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон өдрөөс хойш 5 жилийн дараа
Компани давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ	Нэрлэсэн үнээр буюу нэг бүр нь 5,000 (таван мянган) төгрөг
Ногдол ашиг олгох валют	Төгрөг

Ногдол ашгийн хувь хэмжээ /жилээр/	Монголбанкны бодлогын хүү + 5% (эзэмшиж буй давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс тооцно)
Ногдол ашгийн хувь хэмжээг тооцох суурь	Тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн Монголбанкны бодлогын хүүг үндэслэнэ.
Ногдол ашиг олгох давтамж	Жил бүр (дараа жилийн 4 сарын 30-ны өдрөөс өмнө олгоно)
Татан буулгалтын үнэ	Давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнээр

- Давуу эрхийн хувьцаа шинээр гаргасантай холбогдуулан Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 47,193,951,800 (дөчин долоон тэрбум нэг зуун ерэн гурван сая есөн зуун тавин нэгэн мянга найман зуун) төгрөгөөр тогтоосугай.
- Давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдан авах нөхцөлийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хувьцаа захиалгын гэрээнд тусгаж, уг гэрээний загварыг батлахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
- Давуу эрхийн хувьцааг хаалттай хүрээнд гаргахтай холбогдуулан давуу эрхийн хувьцаа эзэмшигчтэй Хувьцаа захиалгын гэрээг Компанийн нэрийн өмнөөс байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д олгосугай.
- Энэхүү тогтоолд тусгасан нөхцөл болон давуу эрхийн хувьцааг компанид эргүүлэн худалдах эрхийг хэрэгжүүлэх нөхцөл, давуу эрхийн хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, компани татан буугдах үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлбөр төлөх журам, дэс дарааллыг тусгасан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Давуу эрхийн хувьцаа гаргахтай холбогдуулан Компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах талаар Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ХК-д шаардлагатай материалыг хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх, бүртгэл хийлгэхтэй холбоотой шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай.
- Давуу эрхийн хувьцаа гаргаж, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай биелснээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

Тавдугаарт Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ____ дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэл болон эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг удирдан зохион байгуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг танилцуулснаар хурал 16 цаг 15 минутад хурал өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Д.БАЯСГАЛАН

